

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.160

| | |
|------------------------------------|---------------------------|
| Дүнсэн тамхи. Ерөнхий шаардлага | MNS 6274 : 2013 |
| Pipe tobacco. General requirements | MNS 6274 : 2011-ийн оронд |

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

Энэхүү стандартыг 2014 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь дүнсэн тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих шаардлагыг тогтооход оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Дүнсэн тамхийг үйлдвэрлэх, савлах, шошголох, шалгах, хадгалах, тээвэрлэх, борлуулахад хамаарна.

2.2 Энэхүү стандартыг дүнсэн тамхийг үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч, хэрэглэгч болон хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөнө.

3 Норматив ишлэл

Энэ стандартад ишлэл хийсэн дараах стандарт, баримт бичиг, тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс иш татаж хэрэглэнэ.

- MNS ISO 10185 Тамхи ба тамхин бүтээгдэхүүн. Тайлбар толь ;
- ГОСТ 858 Ороох зориулалттай тамхи. Техникийн ерөнхий шаардлага
- ГОСТ 7823 Гаансны зориулалттай тамхи. Техникийн ерөнхий шаардлага
- MNS CAC/RCP 1 Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим
- MNS 4244 Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага;
- MNS 4968 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
- MNS 5364 Хүнсний барааны агуулах. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 6274 : 2013

- MNS ISO 4874 Тамхи. Түүхий эдийн багцаас дээж авах. Ерөнхий зарчмууд;
- MNS 5128 : 2002 Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Никотин ба бохины хэмжээг тодорхойлох. Жингийн арга
- Эд зүйлийг хураан авах, улсын орлого болгох тухай Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журам

4 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог MNS ISO 10815, Тамхи ба тамхин бүтээгдэхүүн. Тайлбар толь стандартын дагуу ойлгоно.

4.1 Дүнсэн тамхи

Тамхины ургамлын навчийг технологийн дагуу боловсруулж, үнэр, амт оруулсан буюу оруулаагүй, гар аргаар ороох болон гаансаар татах зориулалттай, савласан тамхин бүтээгдэхүүний төрөл

5 Техникийн ерөнхий шаардлага

5.1 Дүнсэн тамхийг батлагдсан технологийн заавар, жор, орцын дагуу MNS 4968:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэнэ.

5.2 Дүнсэн тамхийг үйлдвэрлэхэд хэрэглэх түүхий эд, туслах материал нь MNS CAC/RCP 1 “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим” стандартын шаардлага хангасан байна.

5.3 Дүнсэн тамхи импортлоход чанар, аюулгүй байдлын талаар үйлдвэрлэгч орны эрх бүхий байгууллагуудаас олгосон холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байна.

5.4 Дүнсэн тамхины биологийн үзүүлэлт

- Хөгцний болон ялзарсан үнэргүй, тухайн нэр төрөлдөө тохирсон үнэртэй байна.
- Хөлдөж, хөгцөрч, норж муудаагүй байна.
- Хортон шавьж, хачиг, өндөг, авгалдай байж болохгүй.

5.5 Дүнсэн тамхины физикийн үзүүлэлтүүд нь 1 дүгээр хүснэгтэд заасан үзүүлэлт шаардлагыг хангасан байна.

Дүнсэн тамхины физикийн үзүүлэлт

1-р хүснэгт

| № | Үзүүлэлтийн нэр | Тоо хэмжээ |
|---|---|------------|
| 1 | Чийглэг, %-иар | 11 ± 2 |
| 2 | Тамхинд агуулагдах тоосны хувь, %-иас ихгүй | 3,0 |
| 3 | Сав, боодол дээр заасан жингийн хэлбэлзэл , %-иас ихгүй | 5,0 |
| 4 | Нийлбэр гамма идэвхжил (хяналтын түвшин), Бк/г | 250,0 |

5.6 Дүнсэн тамхины химийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангасан байна.

Дүнсэн тамхины химийн үзүүлэлт

2-р хүснэгт

| д/д | Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
|-----|--------------------|-------------|--------------------------|
| 1 | Никотин, ихгүй | мг/г | 1,5 |
| 2 | Пестицид, мг/кг | мг/кг | байж болохгүй |
| 3 | Мансууруулах бодис | - | |
| 4 | Афлатоксин | - | |

6 Шалгаж, хүлээн авах

6.1 Дүнсэн тамхины гаднах байдал (тамхины цаас, хайрцаг)-ыг А хавсралтын дагуу шалгаж хүлээн авна.

6.2 Дүнсэн тамхийг хэсэг /парт/-ээр хүлээн авна.

Парт: Парт гэдэг нь нэг буюу хэд хэдэн шинж чанараараа ижил төстэй, хэвийн нөхцөлд бэлтгэсэн тодорхой тооны тамхи (MNS ISO 10185)

6.3 Хайрцаг тус бүрээс 3 боодол дээжийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авна.

6.4 Дүнсэн тамхины чанарыг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна. Үүнд:

6.4.1 MNS 5127 Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Чийг тодорхойлох. Жингийн арга

6.4.2 MNS 5128 Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Никотин ба бохины хэмжээг тодорхойлох. Жингийн арга

6.4.3 MNS ISO 4389 Тамхи ба тамхин бүтээгдэхүүн. Хлорт органик пестицидийн үлдэгдэл тодорхойлох. Хийн хроматографийн арга

MNS 6274 : 2013

- 6.4.4 MNS 5129** Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Хлорторганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга
- 6.4.5 MNS 5130** Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Фосфорорганик пестицид тодорхойлох. Нимгэн үет хроматографийн арга
- 6.4.6 MNS ISO 13276** Тамхи ба тамхин бүтээгдэхүүн. Никотины цэвэршилтийг тодорхойлох. Цахиур хүчлийн вольфрамын тусламж-тайгаар тодорхойлох жингийн арга
- 6.4.7 MNS 5069** Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс зэрэг ургамлын гаралтай бүтээгдэхүүнд цацраг идэвхит элемент тодорхойлох гамма спектрийн арга

7 Шалгах арга

7.1 Дээж авах

Хайрцаг тус бүрээс 3 боодол дээжийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авна.

7.2 Чийглэгийг тодорхойлох

MNS 5127 “Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Чийгийн агууламжийг тодорхойлох. Жингийн арга” стандартын дагуу тодорхойлно.

7.3 Дүнсэн тамхин дахь тоосыг тодорхойлох

7.3.1 Багаж хэрэгсэл

- 0,01 г-ын нарийвчлалтай лабораторийн жин
- Эксикатор
- Тамхины навчны бохирдол тодорхойлох багаж хэрэгсэл (ЗЛТ),
- IEL 200 маркийн минутад (180 ± 5) эргэлттэй бага оврын шигших төхөөрөмж,

Дээрх төхөөрөмж нь (200 ± 5) мм-ийн голчтой иж бүрэн тортой байна. Үүнд:

- Дээд талын шигшүүрийн тор нь 1 - 29 -1 x 0,8 буюу 1- 30- 1 x 0,8 харьцаатай байна.
- Доод талын шигшүүр нь 028 буюу 0315-ын хагас тороор хийгдсэн байна.
- Тоос цуглуулах тавиур

7.3.2 Туршилтад бэлтгэх

7.3 дахь заалтын дагуу сонгосон тамхины дээжийг болгоомжтой хольж, амархан сэвсийлгэхийн тулд эксикатор буюу камерт ($15\pm 0,5$) %- чийглэгтэй болтол тавиад дараа нь түүнээсээ (50 ± 1) г дээж авна.

7.3.3 Шинжилгээний явц

Тамхины дээжийг эргэдэг шигшүүрийн дээд талын торон дээр тавьж (60±5) минут шигших буюу IEL 200 маркийн шигшүүр дээр (80±6) минут шигшинэ. Өөр маркийн шигших машин байвал норматив-техникийн баримт бичгийг үндэслэнэ. Дээд талын торонд тамхины ширхэг, доод талын торонд жижиг хэсгүүд буюу тамхины тоос үлдсэнийг тавиур дээр цуглуулж 0,01 г-ын нарийвчлалтай жингээр жинлэнэ.

7.3.4 Үр дүнг боловсруулах

Тамхины нийт хэсэг (X)-ийг тодорхойлохдоо дараах томъёогоор тооцож хувиар илэрхийлнэ.

$$X = \frac{m_6}{m_7} \times 100,$$

m_6 –тамхины нийт жин, г-аар;

m_7 - тамхины дээжийн жин, г-аар;

Туршилтын үр дүн нь 2 зэрэгцээ тодорхойлолтын үр дүнгийн дундаж арифметик утга, тамхины ширхэгийн хэсэг 5%, тамхины тоос 0,5%-иас хэтрэхгүй байна. Үр дүнг эхний аравтын тэмдэг хүртэл тооцож гаргана.

7.4 Дүнсэн тамхины ширхэгийн өргөнийг тодорхойлох

7.4.1 Багаж хэрэгсэл

Микроскоп, 10^{\times} хүртэл томруулдаг шил эсвэл ±0,1 мм хүртэл алдаа заах хэмжих бусад төрлийн хэмжигч

7.4.2 Шинжилгээний явц

Тамхины 10 ширхэгийг сонгон авах бөгөөд тамхины судал болон тамхины навчны тасархай орж болохгүй. Ширхэгийг тэгшлээд, өргөнийг хэмжинэ.

7.4.3 Үр дүнг боловсруулах

Туршилтын үр дүнг 10 хэмжилтийн арифметик дундажаар гаргана. Тооцоог зууны нарийвчлалтай гаргаж, аравтын нарийвчлалаар дэвшүүлэн тэгшитгэнэ.

8 Савлах, шошголох

8.1 Дүнсэн тамхины цэвэр жин 200-500 г-аас ихгүй хэмжээтэй байна.

8.2 Дүнсэн тамхийг стандартын шаардлага хангасан, тамхины чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй сав баглаа, боодолд савлана.

8.3 Дүнсэн тамхины боодол дээрх мэдээллийг Монгол хэлээр бичсэн байна.

Үүнд:

- Бүтээгдэхүүний нэр, төрөл;
- Үйлдвэрлэсэн улс
- Үйлдвэрлэсэн он, сар, өдөр;
- Хадгалах хугацаа;
- Үйлдвэрлэгч /импортлогч/-ийн нэр;
- Стандартын дугаар;
- Цэвэр жин.
- Партийн дугаар
- Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тэмдэглэл

8.4 Боодолтой тамхийг үелээт наамал картон буюу фанер авдарт савлах бөгөөд стандартын шаардлагад нийцсэн эргэлтийн авдрыг ашиглаж болно.

8.5 Тээвэрлэлт, хадгалалтын үед авдрыг сайтар тагласан байна.

8.6 Дүнсэн тамхины хайрцаг, боодол дээр тухайн тамхийг бусад тамхинаас илүү хор нөлөө багатай гэсэн утгатай үг бичих буюу түүнтэй адилтгах тэмдэг, дүрс, өнгө, тэдгээрийн хослол хэрэглэхийг хориглоно.

8.7 Дүнсэн тамхины боодол дээрх мэдээллийг эрүүл мэндийн зурагтай анхааруулгатайгаас бусад аль ч хэсэгт тавьж болно.

9 Эрүүл мэндийн анхааруулга

9.1 Эрүүл мэндийн анхааруулга нь тамхи татсан, дам тамхидалтад өртсөнөөс болж хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг дүрсэлсэн зураг, үндсэн болон тайлбар мэдээллээс бүрдэнэ.

9.2 Эрүүл мэндийн анхааруулгыг дүнсэн тамхины боодлын шошгон дотор багтаан хэвлэсэн байна.

9.3 Үйлдвэрлэж, импортолж байгаа дүнсэн тамхинд эрүүл мэндийн зургаан төрлийн зурагт анхааруулгыг ижил тоогоор хэрэглэсэн байна.

9.4 Эрүүл мэндийн зурагт анхааруулга нь тамхины хайрцагны гадаргуугийн доод хэсэгт байрлах ба 50 хувиас доошгүй талбайг эзэлсэн байна.

9.5 Эрүүл мэндийн зурагт анхааруулга нь эх хувьтайгаа адилхан, тусгал сайтай тод харагдахуйц, 4 өнгөтэй байх ба 1 мм-ийн өргөн хар өнгийн хүрээтэй байна.

9.6 Зурагт анхааруулгын талбайд ямар нэгэн өөр зураг, бичиглэл хийхгүй.

9.7 Эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбарын талбайн хэмжээ уртаараа 5 см, өргөнөөрөө 2 см буюу 10 см²-аас доошгүй талбайг эзэлсэн байна.

9.8 Эрүүл мэндийн зурагт анхааруулгын бичвэр тус бүрийг дараах байдлаар бичнэ. Үүнд:

- 1 дүгээр зураг: **“Тамхи ГОО САЙХНЫГ гутаана.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...гутаана.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“ГОО САЙХНЫГ”** гэсэн бичиглэлийг **“Arial”**- фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“16”**

хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу цагаан дэвсгэр дээр улаанаар бичнэ.

- 2 дугаар зураг: **“Тамхи хорт хавдар үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“хорт хавдар”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“20”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 3 дугаар зураг: **“Тамхи бэлгийн сулрал үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“бэлгийн сулрал”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 4 дүгээр зураг: **“Тамхи ҮХЖИЛ үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“ҮХЖИЛ”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“20”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 5 дугаар зураг: **“Тамхи - үхлийн хор мөн.”** гэсэн бичиглэлийн **“Тамхи...”**, **“...мөн.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“14”** хэмжээгээр, **“үхлийн хор”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.
- 6 дугаар зураг: **“Тамхи ургийн гаж хөгжил үүсгэнэ.”** бичиглэлийн **“Тамхи ургийн...”**, **“...үүсгэнэ.”** гэсэн бичиглэлийг компьютерийн **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“12”** хэмжээгээр, **“гаж хөгжил”** гэсэн бичиглэлийг **“Arial”**-фондын, **“bold”** хэлбэр, жижиг үсгийн **“18”** хэмжээгээр, зургийн баруун дээд хэсэгт шар өнгөөр бичнэ.

9.9 Дүнсэн тамхийг бөөнөөр савласан авдрын хажуу талд тухайн тамхины эрүүл мэндийн зурагт анхааруулгын загварыг цаасан дээр хэвлэн байрлуулсан байна.

9.10 Эрүүл мэндийн зурагт анхааруулгыг боодол дээр “С”, “авдар дээр “D” хавсралтад заасны дагуу тус тус байрлуулна.

10 Тээвэрлэх, хадгалах, устгах

10.1 Дүнсэн тамхийг шаардлага хангасан хуурай, цэвэр, гадны элдэв үнэргүй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

10.2 Дүнсэн тамхийг MNS 5364:2004 “Хүнсний барааны агуулах. Техникийн ерөнхий шаардлага” стандартын 4.6 дахь заалт “Төрөлжсөн агуулах - Хадгалах онцгой нөхцөл (халуун, хүйтэн, агаарын харьцангуй чийг тохируулах гэх мэт) горим шаарддаг

MNS 6274 : 2013

тодорхой бүлгийн бараа хадгалах зориулалттай агуулах"-ын шаардлагыг хангасан агуулахад хадгална.

10.3 Дүнсэн тамхийг хадгалах байр нь (65 ± 5) хувийн харьцангуй чийгшилтэй, хуурай, цэвэр, агааржуулалт сайтай байна.

10.4 Дүнсэн тамхийг үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

10.5 Стандартын шаардлага хангахгүй болсон дүнсэн тамхийг эрх бүхий байгууллагаас батлагдсан холбогдох дүрэм, журмын дагуу устгана.

ТӨГСӨВ.

“А” Хавсралт (мэдээллийн)

Дүнсэн тамхины гаднах байдлыг үнэлэх

Дүнсэн тамхины гаднах байдлыг дараах аргаар үнэлнэ.

1 Дүнсэн тамхины гаднах байдлын гэмтэл согогийг их, дунд, бага гэсэн 3 төрөлд хувааж үнэлнэ.

1.1 Их гэмтэл, согогт тооцох үзүүлэлт

Дүнсэн тамхины гадна байдал: тамхины боодлын цаас цоорсон, машины тосны толбонд шарласан, зориулалтын бүрхүүлийн бүрэн бүтэн байдал алдагдсан; боодлын аль нэг талын наалт салсан, тамхины жин дутсан, тамхи гадны хольцтой байх зэрэг (тамхины цаасны уранхай тасархайгаас өөр);

1.2 Дунд гэмтэл, согогт тооцох үзүүлэлт

Дүнсэн тамхины гадна байдал: тамхины боодлын аль нэг талын наалт салсан; шошгон дээрх бичиг хөдөлсөн эсвэл ойлгогдохгүй, боодлын цаас цоорч сэмэрсэн дүнсэн тамхин дээр тухайн оноосон нэр байхгүй; 3 мм-ээс ихгүй машины тосны толботой; тамхин дотор тамхины ороолтын цаасны уранхай тасархай байх зэрэг;

1.3 Бага согогт тооцох үзүүлэлт

Дүнсэн тамхины гаднах байдал: будаг болон цавуугаар бага зэрэг бохирдсон, оноосон нэр ойлгогдохгүй, тамхины боодлын цаас үрчийсэн, боодлын хэлбэр үл мэдэг гажсан зэрэг

2 Тамхины боодлыг үнэлсэн 3 төрлөөс тамхины нэг дээжийг сонгон авч согогийн дагуу дахин 3 хэсэгт ангилна. Хэрэв хайрцаг болон тамхинд нэг зэрэг хэд хэдэн төрлийн гэмтэл согог илэрсэн тохиолдолд хамгийн их согогтойгоор нь тооцно. Хэрэв хайрцаг юмуу тамхинд нэг янзын гэмтэл давтагдвал нэг төрлийн гэмтэл гэж үзнэ.

3 Их гэмтэл согогтойг 10 оноогоор, дунд гэмтэл согогтойг 3 оноогоор, бага согогтойг 0,5 оноогоор тус тус дүгнэнэ. Төрөл болгоноос гэмтэлтэй хайрцаг, тамхины тоог гаргана. Тамхины болон хайрцагны гадна байдлын ерөнхий дүнг дараах томъёогоор гаргана.


$$O = 10A + 3B + 0,3B$$

үүнд : А - их гэмтэл согогтой тамхи болон хайрцагны тоо;
 Б - дунд гэмтэл согогтой тамхи болон хайрцагны тоо;
 В - бага согогтой тамхи болон хайрцагны тоо.

“В” ХАВСРАЛТ (норматив)

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГЫН ЗАГВАР

Зурагт анхааруулга №1



Зурагт анхааруулга №2



Зурагт анхааруулга № 3



Зурагт анхааруулга №4



Зурагт анхааруулга №5



Зурагт анхааруулга №6



**С” ХАВСРАЛТ
(норматив)**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХААРУУЛГЫГ ДҮНСЭН ТАМХИНЫ
БООДОЛ ДЭЭР БАЙРЛУУЛАХ ЗАГВАР**



**“D” ХАВСРАЛТ
(норматив)**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХААРУУЛГЫГ ДҮНСЭН ТАМХИНЫ
АВДАР ДЭЭР БАЙРЛУУЛАХ ЗАГВАР**

